



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баян-Өндөр сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/98/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот
2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 7044-2584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 7044-2424 Цахим хаяг: tsetsegmaad@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Должмаа

Утас: 88119345 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.02.25 № 2/57

танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баян-Өндөр сумын ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баян-Өндөр сумын ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баян-Өндөр сумын ИТХ-ын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн

2515096

бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Баян-Өндөр сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ИТХ-ын нарийн бичгийн дарга Э.Бүжмаа-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өндөр сумын ИТХурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өндөр сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.24-нөөс 2019.02.24-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б. Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баян-Өндөр сумын ИТХурал 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2019.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баян-Өндөр сумын ИТХурлын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баян-Өндөр сумын ИТХурал нь "Үйл ажиллагаандаа ардчилсан зарчим, шударга ёс, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн, удирдлагын төвлөрлийг сааруулах, нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлэн хөгжүүлэх, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад гол анхаарлаа хандуулах" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Баян-Өндөр сумын ИТХурлын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баян-Өндөр сумын ИТХурлын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

- Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байхгүй.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баян-Өндөр сумын ИТХурлын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд 44 оноотой үнэлэгдсэн тул мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзэж, аудитыг томилогдсон аудитор гүйцэтгэлээ.

Баян-Өндөр сумын ИТХурал санхүүгийн тайланг бэлтгэхдээ "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн Acolous 4.01, цалингийн Payroll" программ хангамж ашигладаг байна.

Баян-Өндөр сумын ИТХурлын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баян-Өндөр сумын ИТХурлын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Баян-Өндөр сумын ИТХ-ын 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 49382,5 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 987,7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илрээгүй.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	0.10	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	2	0.10	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхдээ батлагдсан төсвийг зөв тайлагнаагүйгээс тайланг 0,9 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна. Иймд сүүлийн тодотгосон төсвийн хуваарийн дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланд залруулга хийв.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баян-Өндөр сумын ИТХурал чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 45496,2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 40350,9 мянган төгрөг буюу 88,7 хувьтай байгаа нь сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга жирэмсний амралтаа авсан, олон нийтийн цагдаа шилжсэнээс цалингийн зардал 3.2 сая, эд хогшил худалдан авах зардал 1.5 сая төгрөгөөр хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

Өөрийн орлогын төлөвлөгөө байхгүй.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баян-Өндөр сумын ИТХурал Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх онд итгэл үзүүлсэн тул санхүүгийн тайлангийн аудит хийгдээгүй байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баян-Өндөр сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баян-Өндөр сумын ИТХурлын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баян-Өндөр сумын ИТХурлын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Жирэмсэн амаржсан даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг нийгмийн даатгалд 06 кодоор мэдээлэхийг 17 кодоор мэдээлсэн байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нийгмийн даатгалын тухай хуулийн 14, 17 дугаар зүйлийг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Цалин, НДШ буруу тайлагнасан болон илүү дутуу олгосон байх,

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Жирэмсэн амаржсан даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг зөв кодоор мэдээлж байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна.

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

2018 оны эцэст 129990 төгрөгийн номыг тоолоогүй орхигдуулсан байна.

Энэ нь Оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх заалтыг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Тооллого, тооцоог чанаргүй гүйцэтгэсэн байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Эд хөрөнгийн тооллогыг чанартай гүйцэтгэж, нярвын бэлтгэсэн тайланд тавих хяналтыг сайжруулах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 05 дугаар сарын 01-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,747,000.00</u>	<u>2,269,400.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	1,747,000.00	2,269,400.00
354	Хангамжийн материал	1,747,000.00	2,269,400.00
35410	Бичиг хэргийн материал	101,500.00	240,100.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	383,800.00
35470	Бусад хангамжийн материал	1,645,500.00	1,645,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,610,947.76</u>	<u>1,915,247.72</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,610,947.76	1,915,247.72
392	Биет хөрөнгө	2,610,947.76	1,915,247.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	16,095,222.00	00.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-16,095,222.00	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	6,877,870.00	3,909,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,405,869.96	-2,860,199.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,625,000.00	2,625,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1,626,042.28	-1,888,542.40
39217	Ном	139,990.00	129,990.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-300,000.00	-300,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,357,947.76</u>	<u>4,184,647.72</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,357,947.76</u>	<u>4,184,647.72</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,357,947.76	4,184,647.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,820,070.00	4,820,070.00
51101	Өмч: - төрийн	4,820,070.00	4,820,070.00
512	Хуримтлагдсан үр дүн	-1,366,522.24	-1,539,822.28
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,366,522.24	-1,366,522.24
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-173,300.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	904,400.00	904,400.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,357,947.76</u>	<u>4,184,647.72</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	52,264,000.00	49,209,244.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	52,264,000.00	49,209,244.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,500,000.00	736,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	736,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,764,000.00	45,496,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,764,000.00	45,496,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	2,977,044.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	2,977,044.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	53,852,917.03	49,372,544.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	53,852,917.03	49,372,544.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,968,793.03	41,150,252.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	33,307,154.00	30,966,356.00
210101	Үндсэн цалин	33,307,154.00	30,966,356.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,666,422.00	3,669,586.00
210201	Тэтгэврийн даатгал	3,666,422.00	2,399,730.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	319,265.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	253,490.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	63,374.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	633,727.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,972,450.00	2,381,610.00
210401	Бичиг хэрэг	488,000.00	322,930.00
210402	Тээвэр, шатахуун	2,059,450.00	2,028,680.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,000.00	30,000.00
210408	Бараа материал акталсны зардал	410,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,103,600.00	38,500.00
210604	Урсгал засвар	1,103,600.00	38,500.00
2107	Томилолт, зочны зардал	924,000.00	1,159,500.00
210702	Дотоод албан томилолт	924,000.00	1,159,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	900,200.00	703,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	900,200.00	703,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,094,967.03	2,231,700.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	546,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	375,050.00	999,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	719,917.03	685,700.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,884,124.00	8,222,292.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,611,600.00	3,077,044.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	2,977,044.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,011,600.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	100,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,535,724.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,535,724.00	00.00

Баян-Өндөр сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	736,800.00	5,145,248.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	736,800.00	5,145,248.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-1,588,917.03	-163,300.04
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	10,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	10,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-10,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-1,588,917.03	-173,300.04

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	52,264,000.00	49,209,244.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	52,264,000.00	49,209,244.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,500,000.00	736,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	736,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,764,000.00	45,496,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,764,000.00	45,496,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	2,977,044.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	2,977,044.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	52,264,000.00	49,209,244.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	52,264,000.00	49,209,244.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42,379,876.00	40,986,952.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	33,307,154.00	30,966,348.00
210101	Үндсэн цалин	33,307,154.00	28,845,006.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	2,121,342.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,666,422.00	3,669,594.00
210201	Тэтгэврийн даатгал	3,666,422.00	3,047,054.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	101,903.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	81,524.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	20,378.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	418,735.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,486,450.00	2,871,010.00
210401	Бичиг хэрэг	391,000.00	443,530.00
210402	Тээвэр, шатахуун	2,059,450.00	2,412,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	36,000.00	15,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	644,600.00	38,500.00
210604	Урсгал засвар	644,600.00	38,500.00
2107	Томилолт, зочны зардал	924,000.00	1,159,500.00
210702	Дотоод албан томилолт	924,000.00	1,159,500.00

Баян-Өндөр сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	900,200.00	736,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	900,200.00	736,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	451,050.00	1,546,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	546,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	451,050.00	999,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,884,124.00	8,222,292.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,611,600.00	3,077,044.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	2,977,044.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,011,600.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	100,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,535,724.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,535,724.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	736,800.00	5,145,248.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	736,800.00	5,145,248.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,820,070.00	904,400.00	222,394.79	5,946,864.79
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,820,070.00	904,400.00	222,394.79	5,946,864.79
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	3,033,495.99	3,033,495.99
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,820,070.00	904,400.00	-1,366,522.24	4,357,947.76
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,820,070.00	904,400.00	-1,366,522.24	4,357,947.76
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-173,300.04	-173,300.04
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,820,070.00	904,400.00	-1,539,822.28	4,184,647.72

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	50,764,100.00	47,228,276.00	45,496,200.00	40,350,952.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,764,100.00	47,228,276.00	45,496,200.00	40,350,952.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,152,400.00	41,616,676.00	45,396,200.00	40,250,952.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,144,400.00	33,307,154.00	34,152,000.00	30,966,348.00
210101	Үндсэн цалин	00.00	00.00	30,552,000.00	28,845,006.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00	3,600,000.00	2,121,342.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,122,400.00	3,666,422.00	4,098,300.00	3,669,594.00
210201	Тэтгэврийн даатгал	00.00	00.00	2,764,700.00	3,047,054.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	332,900.00	101,903.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	266,800.00	81,524.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	66,800.00	20,378.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	667,100.00	418,735.00
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	00.00	2,873,900.00	2,871,010.00
210401	Бичиг хэрэг	377,000.00	391,000.00	416,700.00	443,530.00
210402	Тээвэр, шатахуун	2,188,200.00	2,059,450.00	2,413,600.00	2,412,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	50,000.00	36,000.00	43,600.00	15,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	00.00	1,550,000.00	38,500.00
210602	Тавилга	450,000.00	00.00	1,550,000.00	00.00
210604	Урсгал засвар	200,000.00	644,600.00	00.00	38,500.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	00.00	1,172,000.00	1,159,500.00
210702	Дотоод албан томилолт	939,000.00	924,000.00	1,172,000.00	1,159,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	156,400.00	137,000.00	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	525,000.00	451,050.00	1,550,000.00	1,546,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	525,000.00	00.00	550,000.00	546,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	451,050.00	1,000,000.00	999,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00	100,000.00	100,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	00.00	100,000.00	100,000.00

Баян-Өндөр сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,611,700.00	5,611,600.00	100,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	00.00	100,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	50,764,100.00	47,228,276.00	45,496,200.00	40,350,952.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	50,764,100.00	47,228,276.00	45,496,200.00	40,350,952.00
132001	Орон нутгийн төсвөөс	50,764,100.00	47,228,276.00	45,496,200.00	40,350,952.00